



# ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

АЗДТГ-ын байр А корпус 1 давхар,  
8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас: 7038 8849, 7038 8821, Факс: 7038 8848  
Цахим шуудан: khuvs gul-tender@khs.gov.mn

2024.09.23 № 1/492  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

## ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НАРЫН АНХААРАЛД

Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Арбулаг, Бүрэнтогтох, Шинэ-идэр сум/ нийлүүлэх гүйцэтгэгч сонгох БХБЯ/20240101021 дугаартай тендер шалгаруулалтын 2024 оны санхүүжилтийг аймгийн Засаг даргын А/487 захирамжийн дагуу санхүүжүүлэхээр болсон тул үе шатны хуваарьт тусгаж ирүүлнэ үү.

Хавсралт: 2 хуудастай



Б.ДОЛЖИНСОРОГДОГ

d/A5

6712003387



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/487

Мөрөн сум

Захирамжийн хавсралтад өөрчлөлт  
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдана авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/419 тоот захирамжийн хавсралт-1, хавсралт-2-ыг тус тус хүчингүй болгосугай.

2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Улаан-Уул, Мөрөн, Эрдэнэбулган сум/” барих ажлын жагсаалт, төсөвт өртгийг 01 дүгээр хавсралтаар “Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Арбулаг, Бүрэнтогтох, Шинэ-Идэр сум/ ажлын жагсаалт, төсөвт өртгийг 02 дугаар хавсралтаар баталсугай.

3.Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсоргодог)-д үүрэг болгосугай.

4.Дээрх төсөл арга хэмжээг Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Арбулаг, Бүрэнтогтох, Шинэ-Идэр/ барих ажлын гүйцэтгэгч сонгох худалдан авах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

5.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

6712011422



Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дугаар  
сарын 20-ны өдрийн А/17 дугаар  
захирамжийн хавсралт-2

НИЙТИЙН ХАЛУУН УСНЫ БАРИЛГА /ХӨВСГӨЛ, АРБУЛАГ, БҮРЭНТОГТОХ, ШИНЭ-ИДЭР  
СУМ/ БАРИХ АЖЛЫН ХҮРЭЭНД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2024 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Үйл ажиллагаа	Төсөвт өртөг	Батлагдсан төсөв /2024/
1	Нийтийн халуун усны барилга /Арбулаг сум/	576,700,000	519,000,000
2	Нийтийн халуун усны барилга /Бүрэнтогтох сум/	576,700,000	
3	Нийтийн халуун усны барилга /Шинэ-Идэр сум/	576,700,000	
Нийт		1,730,100,000	519,000,000

оОо